

1. Оролцогч бүртгэл илгээхдээ журамтай танилцан, бүртгэлийн хуудсыг бөглөж, холбогдох материалын хамт бүрэн гүйцэт [exhibition@mongolchamber.mn](mailto:exhibition@mongolchamber.mn) хаягт илгээнэ.

**Дутуу илгээсэн бүртгэлийг хүлээн авах боломжгүй.**

Бүртгэл баталгаажсан эсэх талаар хариу мэдэгдсэний дараа төлбөрөө шилжүүлнэ.

2. Танхимын Gold, Platinum, Diamond, Sponsor гишүүний ангилалтай, үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог ААН-үүд гишүүн бус байгууллагаас илүү давуу эрхтэй бүртгүүлнэ.
3. Хятадын зохион байгуулагч талаас үзэсгэлэнд оролцох бараа бүтээгдэхүүний нэр төрлийг төрөлжүүлэн, олон төрлийн бүтээгдэхүүн оролцуулах шаардлага тавьсан тул бараа бүтээгдэхүүний төрлөөс хамааран бүртгэлийн тоо хязгаартай. Бүтээгдэхүүний нэр төрлөөс хамааран зохион байгуулагч сонголт хийн бүртгэх эрхтэй.
4. Зөвхөн Монгол улсын гарал үүслийн гэрчилгээтэй, үндэсний үйлдвэрлэгч ААН-үүдийг бүртгэлд хамруулна.

**Үзэсгэлэнд оролцох журам**

5. 9м2 /3\*3/ хэмжээтэй стандарт талбайд 1 ширээ, 2 сандал, 2 гэрэл, 1 тогны залгуур байна бусад талбайн тохижилтод шаардлагатай зүйлсийг оролцогч өөрөө бэлтгэн авчрах бөгөөд талбайг хаах хөшиг, цоож заавал авч ирж бараа бүтээгдэхүүнээ алдахаас сэрэмжлэх шаардлагатай, өөрийн хариуцлагагүй байдлаас шалтгаалсан аливаа асуудалд зохион байгуулагч хариуцлага хүлээхгүй.
6. Хөтөлбөр, мэдээлэлд заасан хугацааг маш хатуу баримтлах. Хожигдсон хүн өөрөө тухайн газарт хүрч очих эсвэл холбогдох асуудлаа бие даан шийдвэрлэх.
7. МҮХАҮТ-аас олгосон үзэсгэлэнгийн талбайг Хятадуудад шилжүүлэн зарах, бүртгэлгүй байгууллага, хувь хүнтэй дур мэдэн хуваан зогсох, **өөрийн үйлдвэрлэдэггүй, гарал үүсэл тодорхойгүй, бүртгэлгүй бараа** дур мэдэн заран борлуулах зэргийг хатуу хориглоно. Ийм зөрчил гаргасан оролцогчийн талбайг ЗБХ-оос шууд чөлөөлөх ба МҮХАҮТ-ын гишүүн байгууллагын сүлжээний хар жагсаалтад оруулна, төлбөрийг буцаан олгохгүй.
8. Үзэсгэлэн худалдаан дээр борлуулалт хийж байх явцад хуурамч юань авсан, хулгайд бараа бүтээгдэхүүнээ алдсан, үйлчлүүлэгчтэй хувийн маргаан үүссэн тохиолдолд зохион байгуулагч хариуцлага хүлээхгүй.
9. Үзэсгэлэнгийн талбайн хуваарилалтыг оролцогчийн барааны нэр төрөл, бүртгэл, төлбөр төлсөн хугацаа, танхимын гишүүнчлэлийн ангилал зэргээс хамааран зохион байгуулагчид хуваарилах бөгөөд талбайн байршлаас хамааран оролцохгүй болсон тохиолдолд төлбөр буцаагдахгүй.
10. **Үзэсгэлэнд оролцох бараа бүтээгдэхүүн Хятад хэл дээр хаяг, шошготой байна.**
11. Оролцогч нь үзэсгэлэнгийн танхим, зочид буудал, вагон зэрэг олон нийтийн газар бусдыг хэл амаар доромжлох, бусдын тайван байдлыг алдагдуулах, чанга дуу чимээ гаргах, архидан согтуурах зэрэг хэв журмын зөрчил гаргахгүй биеэ зөв авч явна. Гаргасан нөхцөлд тухайн арга хэмжээнд оролцох эрхийг хасан, дараагийн аливаа арга хэмжээнд хамруулахгүй.
12. Оролцогч нь үзэсгэлэнгийн танхим доторх аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж, зохион байгуулагчийн тавьсан шаардлагыг хүлээн авч хамтран ажиллана. Оролцогчийн буруутай, заавар журам дагаж мөрдөөгүй үйлдлээс шалтгаалан хохирол учирсан тохиолдолд оролцогч өөрөө 100% бүрэн төлж барагдуулна.
13. Оролцогч үзэсгэлэнд оролцох боломжгүй болсон тохиолдолд үзэсгэлэн эхлэхээс ажлын 5 хоногийн өмнө зохион байгуулагчид бичгээр мэдэгдэнэ, энэ тохиолдолд зохион байгуулалтын хураамжаас үйл ажиллагааны зардал 20% суутган буцаан олгоно. Заасан хугацаанаас хэтэрсэн тохиолдолд төлбөр буцаахгүй.
14. Давагдашгүй хүчин зүйлс: дайн тулаан, байгалийн гамшиг, халдварт өвчин, бүс нутгийн хууль, төрийн бодлого, ачилт тээвэрлэлт зэргээс хамаарсан бараанд учирсан хохирол эвдрэл гэмтэл, ҮХ хойшлох, завсарлах, цуцлагдах, ҮХ хугацаа богиносгох зэрэг нөхцөл байдлаас үүдсэн хариуцлагыг МҮХАҮТанхим үүрэхгүй болно.

Журамтай танилцаж

зөвшөөрсөн оролцогчийн гарын үсэг: .....

/

**2023 оны 8 сарын 23-27-ны өдрүүдэд зохион байгуулагдах  
“ХЯТАД-ЗҮҮН ХОЙД АЗИЙН XIV ЭКСПО”-д  
оролцогчийн бүртгэлийн хуудас**

/Та хавсралт 1 журмыг сайтар уншиж танилцаад, бүртгэлийн хуудсыг бүрэн гүйцэт бөглөөд, хавсралт журмын хамт гарын үсэг зуран баталгаажуулж [exhibition@mongolchamber.mn](mailto:exhibition@mongolchamber.mn) хаягаар доор бичсэн бүрдүүлэх материалын хамт файлаар ирүүлнэ үү.

**Бүртгэлийн хуудастай хамт заавал хавсарган ирүүлэх материалууд:**

1. ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
2. Оролцогчдын гадаад паспортын зураг /скан хувилбар/
3. Байгууллагын товч танилцуулга Хятад хэлээр.
4. Бүтээгдэхүүний зураг 10ш-с доошгүй.

1	Байгууллагын нэр, регистрийн дугаар:		
2	Байгууллагын нэр хятад хэлээр:		
3	МҮХАҮТ-ын гишүүн байгууллага эсэх /гишүүн бол гишүүний ангилал бичих/	Тийм	
		Үгүй	
4	Байгууллагын захирлын овог нэр:  Байгууллагын албан ёсны хаяг:  Ажлын утас/ Tel: Гар утас/ Mobile: И-мэйл/E-mail: Website:		
5	Үйл ажиллагааны чиглэл, бүтээглэхүүний нэр төрөл:		
6	Үзэсгэлэнд оролцогчийн мэдээлэл: Овог нэр: Албан тушаал: Гадаад паспортын дугаар: Ажлын утас: Гар утас: И-мэйл: Ви Чат:	<u>Оролцогч 1</u>	<u>Оролцогч 2</u>

Байгууллагын захирлын гарын үсэг /тамга/:

...../

/

утас

2023 оны .....сарын.....өдөр